

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНД ЖЕНДЕРИЙН МЭДРЭМЖТЭЙ ХАНДАХ НЬ

СЭДЭВ: “ЖЕНДЭРИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫГ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН
БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТӨД ТУСГАХ НЬ” АНХДУГААР ЧУУЛГА УУЛЗАЛТ
Чойбалсан хот, Дорнод аймаг
2018 оны 12-р сарын 7-8-ны өдөр

Ч.ЖАВЗАНПАГМА

**ТӨВ АЙМГИЙН ЗДТГ-ЫН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН ДАРГА**

- 1. ОРШИЛ**
- 2. ЖЕНДЕРИЙН МЭДРЭМЖ, МОНГОЛ УЛСЫН ЖИШЭЭ**
- 3. ЖЕНДЕРИЙН МЭДРЭМЖТЭЙ ХЯНАЛТ-
ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭГ НЭВТРҮҮЛЭХИЙН АЧ
ХОЛБОГДОЛ**
- 4. ДҮГНЭЛТ**

Хяналт шинжилгээ үнэлгээний тогтолцоо

- Хяналт-шинжилгээ гэдэг нь нэг хэвийн, тасралтгүй бөгөөд гол шалгуур үзүүлэлтүүдийг ажиглах дотоод үйл ажиллагаа юм
- Шалгуур үзүүлэлт нь тухайн үйл ажиллагааны зорилго, зорилт, гүйцэтгэлтэй холбоотой зорилтот түвшинг тэдгээрийн ахицтай зэрэгцүүлэн хэмжихээр сонгож авсан хэмжүүр юм
- Хяналт, үнэлгээний систем нь байгууллагын бүтэц, удирдлагын үйл явц, стандарт, стратеги, төлөвлөгөө, шалгуур үзүүлэлт, мэдээллийн систем, тайлагнах тогтолцоо, хариуцлагын уялдаа холбооны цогц бүрдэл

ЖЕНДЕРИЙН МЭДРЭМЖ, МОНГОЛ УЛСЫН ЖИШЭЭ

Жендэрийн мэдрэмж гэж эмэгтэй, эрэгтэй хүмүүс, нийгмийн бүлгүүдийн ялгаатай хэрэгцээг, мөн тэдний хөгжлийн үйл явцад оролцох болон үр шимийг нь хүртэхэд хязгаарлалт болж буй хүчин зүйлсийг анхаарч тооцох хүсэл эрмэлзэл, мэдлэг, чадвар бөгөөд жендэрийн хэрэгцээ, түүнд нөлөөлж буй хүчин зүйлд анхаарах явдал юм.

МУ жишээ:

- Эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн зах зээл болон улс төрийн хүрээнд гүйцэтгэх үүрэг адил

(Оросын ШУА-ийн Хүн ам зүйн нийгэм-эдийн засгийн асуудлын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Зоя Хоткина)



ЖЕНДЭРИЙН ЗӨРҮҮТЭЙ БАЙДЛЫН ИНДЕКС - МОНГОЛ УЛС

(Дэлхийн жендэрийн зөрүүтэй байдлын тайлан 2013 он)

Нийт		Эдийн засгийн оролцоо			Боловсрол эзэмших байдал		Эрүүл мэнд ба амьдрах чадвар		Улс төрийн эрх мэдэл	
	Байр	Оноо	Байр	Оноо	Байр	Оноо	Байр	Оноо	Байр	Оноо
Жендэрийн зөрүүтэй байдлын индекс 2013 (136 орноос)	33	0.720	2	0.834	49	0.995	1	0.980	108	0.073
Жендэрийн зөрүүтэй байдлын индекс 2012 (135 орноос)	44	0.711	1	0.839	50	0.994	1	0.980	127	0.032
Жендэрийн зөрүүтэй байдлын индекс 2011 (135 орноос)	36	0.714	3	0.850	47	0.995	1	0.980	125	0.032
Жендэрийн зөрүүтэй байдлын индекс 2010 (134 орноос)	27	0.719	2	0.875	59	0.992	1	0.980	124	0.032
Жендэрийн зөрүүтэй байдлын индекс 2006 (115 орноос)	42	0.682	21	0.704	20	0.999	1	0.980	101	0.046

ЖЕНДЭРИЙН ТЭГШ БУС БАЙДЛЫН ИНДЕКС /БҮС, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР/

Аймаг	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Улсын дүн	0.390	0.345	0.323	0.294	0.289	0.335	0.282
Баруун бүс	0.314	0.321	0.331	0.250	0.234	0.284	0.319
Хангайн бүс	0.803	0.810	0.789	0.795	0.770	0.418	0.448
Төвийн бүс	0.773	0.808	0.782	0.834	0.797	0.349	0.376
<u>Дундговь</u>	<u>0.817</u>	<u>0.820</u>	<u>0.824</u>	<u>0.836</u>	<u>0.821</u>	<u>0.824</u>	<u>0.822</u>
<u>Төв</u>	<u>0.823</u>	<u>0.831</u>	<u>0.817</u>	<u>0.825</u>	<u>0.803</u>	<u>0.810</u>	<u>0.832</u>
Зүүн бүс	0.336	0.828	0.832	0.833	0.783	0.809	0.808
<u>Дорнод</u>	<u>0.815</u>	<u>0.819</u>	<u>0.841</u>	<u>0.842</u>	<u>0.841</u>	<u>0.841</u>	<u>0.839</u>
<u>Сүхбаатар</u>	<u>0.805</u>	<u>0.822</u>	<u>0.819</u>	<u>0.821</u>	<u>0.816</u>	<u>0.836</u>	<u>0.814</u>
Улаанбаатар	0.377	0.288	0.286	0.253	0.266	0.307	0.275
	0.377	0.288	0.286	0.253	0.266	0.307	0.275

ЖЕНДЕРИЙН МЭДРЭМЖТЭЙ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ

Жендэрийн үр нөлөөний үнэлгээ гэж бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаа нийгмийн янз бүрийн бүлгийн эрэгтэй эмэгтэй хүмүүст хэрхэн ялгаатай нөлөөлж байгааг судлан шинжилж, сөрөг нөлөөг нь арилгах арга замыг тодорхойлох хэрэгсэл юм.

Жендэрийн мэдрэмжтэй хяналт үнэлгээний системийн бүрэлдэхүүн хэсгүүд нь:

1. Жендэрийн хамааралтай үр нөлөөний үнэлгээг шийдвэр гаргах байнгын үйл ажиллагаанд нэвтрүүлэх
 2. Жендэрийн үр нөлөөний үнэлгээний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулах, гүйцэтгэлийг хэмжих
 3. Жендэрийн үр нөлөөний үнэлгээний тайлан бичих, танилцуулах
- 

Шалгуур үзүүлэлтүүдийн ангилал (Шалгуур үзүүлэлтүүдийг өргөн хүрээнд нь таван хэсэгт ангилах боломжтой.)	Жендэрийн мэдрэмжтэй шалгуур үзүүлэлтүүдийн жишээ
1. Орцын шалгуур үзүүлэлт Орцын шалгуур үзүүлэлтүүд нь хуваарилах гэж байгаа нөөцийн тоо хэмжээ болон түүнийг зарцуулах цаг хугацааг заадаг.	- Олон нийтэд түшиглэсэн малчдын бүлгийг дэмжих үйл ажиллагаанд эрэгтэй ба эмэгтэй өрхийн тэргүүнтэй айлуудаас оруулж байгаа санхүүгийн хувь хэмжээ - Малчдын бүлгийг дэмжих тэрэг техникийг ажиллуулах эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдэд хамааралтай зардал
2. Явц дундын шалгуур үзүүлэлт Хэрэгжилтийн явцад юу болж байгааг энэ шалгуур үзүүлэлтээр хэмждэг. Үйл явцын шалгуур үзүүлэлт нь тухайн төсөл хөтөлбөр юу хийхийг зорьсон тэдгээрт хамаардаг. Ихэнхдээ үйл ажиллагааны төлөвлөгөөнөөс бодит ажил хэрэг болсон үр дүнгүүдийн цогцоос эдгээр шалгуур үзүүлэлтийг авдаг.	- Зорилтот аймаг, сум, баг, дүүрэгт жендэрийн дүн шинжилгээ хийгдэж байна. - Тодорхой чиглэлээр МСҮТ-д сурч байгаа эрэгтэй, эмэгтэй оюутнуудын тоо - Эмэгтэйчүүдийн өмч эзэмших ба зээлэнд хамрагдах эрхийн төлөө нөлөөллийн кампанит ажил 2016 он гэхэд эхэлсэн байна г.м.
3. Гарцын шалгуур үзүүлэлт Гарцын шалгуур үзүүлэлт нь төслийн санхүүгийн болон материалын гарцыг хэмждэг: материалын хэмжээ, байгууллагын чадавхи, эхний ээлжийн үйлчилгээний урсгал гэх мэт.	- Эмэгтэй ахлагчтай малчдын бүлгийн тоо -Зээлийн хөтөлбөрт хамрагдаж байгаа эрэгтэй/эмэгтэй хүмүүсийн тоо

4. Үр дүнгийн шалгуур үзүүлэлт

Төслийн завсрын буюу дунд хугацааны өөрчлөлтийг хэмждэг. Төслөөс тэтгэлэг авагчдад үзүүлж байгаа шууд үр нөлөөнд түлхүү анхаарал хандуулдаг бөгөөд төслийн үр нөлөө нь анх төлөвлөснөөс өөр болж байгаа эсэхийг хамаардаг.

- Эрэгтэй ажилчидтай харьцуулахад шинэ технологи ашиглаж эхэлсэн эмэгтэйчүүдийн хувь өссөн байдал
- Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн зээлийн эргэн төлөлтийн түвшин өссөн хувь
- Бага ангиас дунд шатны боловсрол эзэмшихээр үргэлжлүүлэн суралцаж байгаа сурагчдын хувь, хүйсээр
- уул уурхайн салбарт ажилд орсон эмэгтэйчүүдийн хувь өссөн байдал
- Эмэгтэйчүүдтэй харьцуулахад эрчүүдийн дундах халдварт бус өвчний тархалтын хувь буурсан байдал.

5. Үр нөлөөний шалгуур үзүүлэлт

Үр нөлөөний шалгуур үзүүлэлтүүд нь дунд хугацааны өөрчлөлтүүдийн үр дүнд илүү сайжирсан урт хугацааны ерөнхий өөрчлөлтийг хэмждэг.

- Эрэгтэй, эмэгтэйчүүдийн дундах ядуурлын түвшингийн бууралт
- Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дунд зам тээврийн осол аваараас үүдэлтэй нас баралтын тоо буурах
- Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн дунд амьжиргааны түвшин сайжирсан байдал

ДҮГНЭЛТ

Цаашид анхаарах зүйлс:

1. Шийдвэр гаргах үйл ажиллагаанд жендерийн хамааралтай үр нөлөөний үнэлгээ хийх.
2. Хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, төлөвлөсөн бодлого, хөтөлбөр маань хүссэн үр дүн, үр нөлөөг бий болгож байгаа эсэхийг харуулахын тулд жендерийн мэдрэмжтэй шалгуур үзүүлэлтүүд боловсруулах.
3. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг танилцуулахдаа жендерийн эрх тэгш байдлыг хангаж байгаа эсэх асуудлыг оруулах.